



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар A/70

Улаанбаатар хот

Журам, дүрэм, батлах
тухай

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5, 23.1.6 дахь заалтыг баримтлан ТУШААХ нь:

1. "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сахилгын дүрэм"-ийг нэгдүгээр, "Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг хоёрдугаар, "Авлигатай тэмцэх газарт иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хянан шийдвэрлэх журам"-ыг гуравдугаар, "Авлигатай тэмцэх газрын даргын зөвлөлийн ажиллах журам"-ыг дөрөвдүгээр, "Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг тавдугаар, Авлигатай тэмцэх газрын албан хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох журам"-ыг зургадугаар, "Авлигатай тэмцэх газрын тээврийн хэрэгсэл ашиглах журам"-ыг долоодугаар, Авлигатай тэмцэх газрын хөдөлмөрийн дотоод журам" /шинэчилсэн найруулга/-ыг наймдугаар, "Авлигатай тэмцэх газрын аюулгүй байдлыг хангах журам"-ыг есдүгээр, "Хяналт шалгалт зохион байгуулах журам"-ыг аравдугаар, "Албаны шалгалт хийх журам"-ыг арваннэгдүгээр, "Мэдүүлэг авах өрөөг ашиглах журам"-ыг арванхоёрдугаар, "Телефон холбоо зохион байгуулах журам"-ыг арвангуравдугаар, "Авлигатай тэмхцэх газрын албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ыг арвандөрөвдүгээр, "Авлигатай тэмцэх газрын мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг арвантавдугаар, "Авлигатай тэмцэх газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас утсаар ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авах журам"-ыг арванзургадугаар, "Хяналт шалгалтын журам"-ыг арвандолоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журмын цахим сан үүсгэж, ашиглалтад нэвтрүүлэхийг Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба /ахлах комиссар Т.Төгөлдөр/-нд, дүрэм, журмыг нийт албан хаагчдад танилцуулахыг хэлтэс, албадын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасанням/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

Х.ЭНХЖАРГАЛ



000104

Авлигатай тэмцэх газрын даргын
2018 оны 07 дугаар сарын 10-ны
өдрийн 14:00 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИЙН
САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Авлигатай тэмцэх газар /цаашид “байгууллага” гэх-/ын албан хаагчийн сахилгын дүрмийн зорилго нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа, захирах, захирагдах ёс, хүний эрхийг хангах, албан хаагчийн баримтлах сахилгын хэм хэмжээг тогтоох, тэдний нэр хүнд, эрх ашгийг хамгаалахад оршино.

1.2 Албан хаагчийг Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, албан хаагчийн тангараг, энэхүү дүрмийг сахин биелүүлэхийг шаардана.

Хоёр. Сахилгын зөрчил

2.1. Сахилгын зөрчил гэж холбогдох хууль тогтоомж болон энэ дүрмээр тогтоосон сахилгын хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

2.2. Сахилгын хэм хэмжээ нь өргөсөн тангарагтаа үнэнч байх, хууль тогтоомжийг дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн тэгш байдлыг хангах, албан үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөлийн нэг тул байгууллагын албан хаагч бүрээс сахилгын хэм хэмжээг заавал сахин биелүүлэхийг шаардана.

2.3 Албан хаагч бүр биеэ авч авах байдлаараа байгууллагын нэр хүндийг цэвэр байлгахыг ямагт хичээж, сахилгын хэм хэмжээг чанд сахин мөрдөх үүрэгтэй.

Гурав. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл

3.1. Авлигатай тэмцэх газрын албан хаагчид дараах үндэслэлээр сахилгын шийтгэл ногдуулна.

3.1.1. Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж зөрчсөн;

3.1.2. Авлигатай тэмцэх газрын удирдах албан тушаалтнаас хуулийг дагаж мөрдөх талаар гаргасан тушаал, үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй;

3.1.3. Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн;

3.1.4. Байгууллагын дотоод дүрэм, журмыг зөрчсөн;

3.1.5. Хуульд заасан албаны чиг үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй;

3.1.6. Албан хаагчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалсан алдаанаас хууль тогтоомж зөрчигдсөн нь тогтоогдсон.

3.2. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, зөрчлийг заавал шалгаж тогтоосон байна.

Дөрөв. Сахилгын зөрчлийн хэм хэмжээ

4.1 Албан хаагч Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан

хаагчийн нийтлэг үүрэг, Авлигын эсрэг хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээс гадна дараах шаардлагыг сахин биелүүлнэ.

4.1.1. Байгууллагын буюу албан хаагчийн нэр хүндийг хамгаалж, хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явулах;

4.1.2. Улс төрийн үзэл бодлоос ангид байж, санаа бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхдээ албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж, төрийн албан хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдлийг гаргахгүй байх;

4.1.3. Албан үүргээ биелүүлэхдээ улсын болон албан ажлын эрх ашгийг ямагт эрхэмлэн дээдэлж, амин хувийн эрх ашигт хөтлөгдөхгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хээл хахуульд автахгүй байх;

4.1.4. Албан тушаалын давуу тал, боломжийг хувийн зорилгоор ашиглах, аливаа этгээдийн өмнө хууль бус үүрэг хүлээх, энэ байдалд өөрийгөө оруулж болзошгүй бэлэг, дурсгалын зүйл, шан харамж авахгүй байх;

4.1.5. Үндсэн ажил, албан үүргээсээ гадуур хуулиар хүлээн зөвшөөрснөөс бусад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байх;

4.1.6. Албан үүрэгтэй холбоотой нь илэрхий болсон буюу эсвэл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

4.1.7. Удирдлагын зөвшөөрөлгүйгээр албан ажлын талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулахгүй байх;

4.1.8. Чиг үүргийн дагуу аливаа асуудлыг шалгахдаа танил тал харах, бусдыг ялгavarлах, хүнд суртал гаргах, чирэгдүүлэх зэргээр хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэх байдал гаргахгүй байх;

4.1.9. Байгууллагын өмч хөрөнгө, техник болон тусгай хэрэгсэл, албан хэрэгцээний мэдээ материалы, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх;

4.1.10. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын цагаар, албаны байранд, мөн үүрэг гүйцэтгэж томилолтоор яваа үедээ согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад эм, бэлдмэл болон бусад бодис хэрэглэхгүй байх;

4.1.11. Байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр албаны болон хувийн ажлаар гадаадад зорчих, түүнчлэн дотоод, гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний зардлаар аялах, жуулчлах, амрахгүй байх;

4.1.12. Аливаа уулзалт, дайллага, хүлээн авалтад оролцохдоо албаны нэр хүндийг дээдэлж, хөндлөнгийн ямар нэг нөлөөнд автахгүй байх;

4.1.13. Албан үүргээ гүйцэтгэхэд иргэн, албан тушаалтнаас нөлөөлсөн дарамт шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар дээд шатны удирдлагад мэдэгдэх;

4.1.14. Удирдах албан тушаалтан албан хаагчтай бүдүүлэг, зохисгүй харьцах, хууль бус үүрэг даалгавар өгөх, өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар дарамт шахалт үзүүлэхгүй байх;

4.1.15. Албан хаагч ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;

4.1.16. Албаны үнэмлэх, тэмдгийг хууль бусаар хэрэглэх, албаны нэрийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх.

Тав. Сахилгын дүрэм зөрчсөн албан хаагчид хүлээлгэх хариуцлага

5.1 Энэ дүрэмд заасан сахилгын хэм хэмжээг зөрчсөн нь тухайн алба хаагчид Төрийн албаны тухай хуульд болон холбогдох бусад хуульд хариуцлага ногдуулах үндэслэл болно.

5.2 Албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэхтэй холбогдсон харилцааг тусгай журмаар зохицуулна.

----000----